

**Монгол улсын бүрэн дунд боловсролын зорилго,
уламжлал, шинэчлэл: эрх зүйн баримт бичгийн шинжилгээ**

*Э.Чулуунцэцэг,
Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургууль, Нийгмийн ухааны тэнхим*

Хураангуй

БСШУСЯ-ны сайд одоо хэрэгжиж буй “хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх цөм хөтөлбөр”-ийг эргэн харах, өөрчлөх талаар мэдэгдэл хийлээ. Тус хөтөлбөрийг өөрчлөх болсон үндэслэлд нь гарцаагүй шалтгаан гэх зүйл тэр бүр сонсогдсонгүй. Бид сүүлийн жилүүдэд шавь төвтэй сургалтын хөтөлбөр, судлагдахуунд суурилсан сургалтын хөтөлбөр, гүйцэтгэлд суурилсан сургалтын хөтөлбөр, үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр, кембрижийн хөтөлбөр, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх цөм хөтөлбөр, түүний хүрээнд дэх “Авьяас”, “Ном”, “Зөв монгол хүүхэд” зэрэг хөтөлбөр, мөн эдгээр хөтөлбөрийг дагасан олон арван төсөл хэрэгжүүлж, боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэлийг хийсээр ирлээ. Шалгарсан сайн туршлагыг судалж, хэрэгжүүлэх үйл явц тасралтгүй өрнөж ирсэн нь сайшаалтай хэрэг боловч “..хийгдэж буй шинэчлэл, өөрчлөлт нь энэ салбарт хөгжлийг авч ирэх ёстой ч тэр бүр тавьсан зорилгодоо хүрэхгүй байна”(Бэгз, 2017, х.10).

Сүүлийн жилүүдэд шинэчлэл нэрийн доор хийгдсэн олон өөрчлөлт нь манай боловсролын салбар тогтвортой биш байгааг харуулж байна гэж хэлж болно. Нөгөө талаас энэ байдлыг эрх зүйн зохицуулалтын тогтворгүй, боловсронгуй бус байгаатай холбоотой гэж үзэж байна. Учир нь ардчилал бол хуулийн засаглал, ардчилсан улс гэдэг бол хуулийн эзэнт гүрэн юм. Ардчилсан засаглалтай, эх газрын эрх зүйн бүлд хамаарах манай улсын хувьд төрөөс бүх нийтийн боловсролын үзэл баримтлал, хэм хэмжээг тогтоож, гүйцэтгэх засаглалын байгууллага биелүүлэх зарчимтай. Гэтэл боловсролын салбарын бодит байдлыг харахад урвуу хамааралтай гэмээр зарим үйл ажиллагааг хууль биш, тодорхой субъект удирдаж, өөрийн хүсэлд нийцүүлэн хуулийг засах хандлага түгээмэл байна. Гүйцэтгэх засаглалын байгууллагаас өөрт таалагдсан, ашигтай гэж үзсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгодоо хөтлөгдөн хуульд өөрчлөлт оруулсаар эдүгээ хүрлээ. Энэ бүхэн нь боловсролын тухай хууль үзэл баримтлалгүй, зохицуулалт сул байгаагийн илэрхийлэл мөн. Иймээс илтгэлийн хүрээнд нэгдүгээрт, манай улсад албан боловсролын үйл явц өрнөсөн цаг үеэс өнөөг хүртэлх боловсролын суурь харилцааг зохицуулж ирсэн эрх зүйн хэм хэмжээнд боловсролын зорилго, үзэл баримтлалыг хэрхэн тодорхойлж ирсэн, хоёрдугаарт, боловсролын шинэчлэлийн үйл явцад уламжлал, үндэсний үнэт зүйлсийг хадгалах хандлага хэр байгааг судлах, гуравдугаарт, бүх нийтийн боловсролын үр ашигтай, тогтвортой байдлыг хангахад нөлөөлөх зарим хүчин зүйлийг тодруулахыг хичээлээ.

Түлхүүр үг

Хууль, өөрчлөлт, үнэт зүйл, бодлого, түүх,

Үндсэн хэсэг

Иргэн бүрд ерөнхий боловсрол заавал эзэмшүүлэх нь Үндсэн хуулиар тогтоосон төрийн үүрэг мөн. Энэ бол дан ганц Монгол улсын Үндсэн хуулийн заалт бус дэлхийн ихэнх улсын Үндсэн хуульд тусгалаа олсон хэм хэмжээ юм. Иймээс төр, захиргааны байгууллагаас бүх нийтийн боловсролд удирдлага болгох үзэл баримтлал, зорилго чиглэл, хөтөлбөр, арга зүйг тогтоож, үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.

Боловсролын эрх зүйн зохицуулалтыг түүхэн талаас нь авч үзэхэд олон судлаачид Монголын боловсролын түүхийг 1921 оноос

эхэлж авч үзсэн байна. Ингэхдээ 1921 оноос эхэлж албан боловсролын байгууллага болох сургууль ажиллаж эхэлсэнтэй холбож тайлбарлажээ. Харин зарим судлаачид энэ санааг шүүмжилж 1921 оноос өмнө манайд боловсрол, гэгээрэл байгаагүй гэж ойлгож болохгүй гэсэн санааг дэвшүүлдэг. Тодруулбал, сүмбэчүүдийн үед буюу МЭ 339 онд их сургууль ажиллаж байсан, тэр их сургууль нь Европын сонгодог их сургуулиудтай хараахан зүйрлэж болохгүй ч хотын сургуулиа хөдөө, гацааны сургуулиас ялгаж их сургууль гэж нэрлэж байсан, мөн их Монгол улсын, манжийн ноёрхлын үеийн төрийн

chuluuntsetseg@gmail.com

анхны сургууль, (Шагдар, 2000, х.38) гэх мэтээр албан боловсролын хөгжлийг нэлээд эрт үеэс авч үзжээ. Эдгээр баримтууд нь албан боловсрол олгох үйл явц 1921 оноос өмнө эхэлж гэдгийг харуулж байна.

Боловсролын философич Джон Дьюи хөгжил дорой нийгэмд албан ёсоор сургах хэрэгцээ бага байдаг болох талаар өөрийн бүтээлдээ онцлон тэмдэглэсэнчлэн 1921 оноос өмнөх нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас хамаарч орчин цагийн сонгодог боловсролын хэв маяг бүрэлдэн бий болох боломж, бололцоо хязгаарлагдмал байж болох юм. Энэ ч утгаараа Ардын хувьсгал ялсны дараахан 1921 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн засгийн газрын 11 дүгээр хурлаар сургуулийн танхим нээж, түүнд хүүхдийг багаас нь сургах тухай хэлэлцэж, Бага сургууль байгуулах тухай тогтоол баталсан нь Монгол Улсад албан боловсролын үйл ажиллагааг зохицуулсан анхны эрх зүйн эх сурвалж байв. Үүний дараагаар Бага сургуулийг дотоод яаманд захируулах ба сургуулийн хэлтэс байгуулах тухай, Анхны багш нарыг урамшуулах тухай, Зөвлөлтийн мэргэжилтэн багш урьж ирүүлэх тухай, Багшлах эрхийн үнэмлэх олгох тухай, Бага сургуулийн хичээлийн жилийн хугацааг тогтоох тухай, Багш нарын анхдугаар их хурал хуралдуулах тухай, Ардыг гэгээрүүлэх яам байгуулах тухай, Ардыг гэгээрүүлэх яамны

дүрэм, Орон нутгийн ардын боловсролын ажил байдлыг хянан шалгах тухай, Багшлах боловсон хүчнийг бэлтгэх тухай, Бичиг үсэг мэддэг иргэн бүр мэддэггүй нэг иргэнд зааж сургах тухай, Ардын олон бага, дунд сургуулийн сурах бичгийн тухай, Бичиг үсэг үл мэдэх явдлыг хэрхэн арилгах тухай гэх зэрэг олон төрлийн хэм хэмжээ тогтоосон акт, захиргааны актуудыг батлан гаргаж, хэрэгжүүлж нийтийн боловсролын үйл ажиллагаанд баримталж иржээ.

Тухайн цаг үеийн онцлог хэрэгцээ шаардлагаас хамаарч төр, захиргааны байгууллагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт нь боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах, сургууль байгуулах, бүх нийтийг бичиг үсэгтэй болгох, дархан урлалын сургуулийг байгуулах зэрэгт анхаарлаа хандуулж байжээ.

1963 оны 2 дугаар сарын 09-ний өдөр Ардын их хурлын IY чуулганаар Сургууль амьдралын холбоог бэхжүүлж, ардын боловсролын системийг хөгжүүлэх тухай 4 бүлэг 49 зүйл бүхий хууль баталсан байна. Энэ хууль нь боловсролын харилцааг цогцоор нь зохицуулахыг эрмэлзсэн анхны бие даасан хууль гэж үзэж болно. Үүний дараагаар 1982 оны Бүгд найрамдах Монгол ард улсын ардын боловсролын тухай хуулийг батлан гаргажээ. Тус хуулиудын зорилгыг авч үзвэл:

Хүснэгт 1

1963 оны хуулийн зорилго	1982 оны хуулийн зорилго
БНМАУ-ын сургуулиудын үндсэн зорилт бол өсвөрийн залуу үеийг боловсролтой, биеийн ба оюуны хөдөлмөрийг хослуулан хийх бэлтгэлтэй, социалист нийгмийн зарчмыг гүнээ хүндэтгэдэг болгож хүмүүжүүлэх явдал мөн. (БСПУЯ, 2014, х.212). <u>хуулийн</u> 1 дүгээр зүйл\	БНМАУ-ын ардын боловсролын хууль тогтоомж нь манай орны иргэдийн ашиг сонирхол, социалист нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын түвшинг байнга дээшлүүлж, улс, ардын аж ахуй, соёлын бүх салбарыг өндөр мэргэжилтэй ажилчин, малчин мэргэжилтнээр аль болох дүүрэн хангах зорилгоор ардын боловсролын салбар дахь нийгмийн харилцааг зохицуулна. (БСПУЯ, 2014, х.133) \хуулийн 1 дүгээр зүйл\

“Боловсрол гэдэг бол хэн нэгэнд зүгээр мэдлэг дамжуулах бус, харин манай иргэншилд гарцаагүй хэрэгтэй үнэт зүйлийг дамжуулж буй үйл явц (Боаз, 2005, х.301) гэж үзвэл дээрх хуулиудад ерөнхийдөө боловсролд социалист нийгмийн үнэт зүйлийг баримжаалж байсан нь хуулийн зорилгоос харагдаж байна. Энэ цаг үед гарсан дэвшил өөрчлөлтийг дарлал, мөлжлөгөөс дөнгөж ангижирсан үндэстэн нийтээр бичиг үсэгтэй, боловсролтой болгож, хүн амыг эрүүлжүүлж, соёлжуулсан гээд магтаал хэлэх олон хүн бий. Нөгөө талаас тухайн үеийн бодит байдал бол бид ЗХУ-ын боловсролын загварыг шууд хуулбарласан гэдэгтээ ч олон

хүн санал нийлнэ. Харин 1990 оноос хойш манай улс нийгмийн тогтолцооны шинэчлэл хийж, социалист эрх зүйн бүл гэгдэж нэгэн үе тусгаарлагдаж, онцлогдож байсан бүлээс сонгодог эрх зүйн бүл болох Эх газрын эрх зүйн бүлд хамаарах болсон. 1992 оны Шинэ Үндсэн хууль баталж, тус хуулиар, Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг

нандигнан өвлөж,
 • хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
 • эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэж зарлан тунхагласан.
 Эдгээр заалт нь бидний бий болгохыг зорьсон, манай иргэншилд гарцаагүй хэрэгтэй

үнэт зүйл мөн. Үндсэн хуулийн энэхүү зохицуулалт боловсролд ч хамааралтай юм.

Манай улс боловсролын харилцааг зохицуулж буй хуулиудыг 1991 оноос 2002 он хүртэл 3-4 жилийн давтамжтай өөрчилж, шинээр баталж, зорилго чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 2

№	Хууль	Зорилго	Гол баримжаалсан үнэт зүйл
1	1991 оны БНМАУ-ын боловсролын тухай хууль	“БНМАУ-д боловсрол нь хүмүүнлэг ардчилсан, тасралтгүй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтний соёл иргэншлийн өв уламжлал, шинжлэх ухаанд үндэслэнэ	соёл, шинжлэх ухаанд түшиглэнэ
2	1995 оны Монгол улсын боловсролын тухай хууль	Шинжлэх ухааны мэдлэг эзэмшсэн, шударга ёс, хуулийг сахидаг, гоо зүйн мэдрэмж таашаалтай, бие даан суралцах, ажиллах, амьдрах чадвар төлөвшүүлэх	иргэний эзэмших чадварыг онцолсон байна хуулийг сахидаг иргэнтэй болох
3	1998 он нэмэлт өөрчлөлтөөр	Иргэний эрүүл, чийрэг, бие бялдар, оюуны зохих чадавхтай, хуулийг дээдлэн сахидаг, хүмүүнлэг, ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж таашаал олж, бие даан амьдрах чадвартай болоход нь үйлчихэд оршино	Хувь хүний эрхэмлэх, үнэт чанаруудыг бий болгоход чиглэсэн Амьдрах чадварт сургах Хуулийг дээдлэн сахидаг
4	2002 оны Боловсролын тухай хууль	Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”	Хүмүүнлэг ёсыг сахидаг иргэн төлөвшүүлэх Ажиллах, амьдрах чадвартай

Хүснэгтээс харахад 1991 оны хуулиар бол боловсрол нь шинжлэх ухаан, өөрийн болон нийт хүн төрөлхтний соёл иргэншлийн өв уламжлалд тулгуурлаж байна. 1995 оны хуульд хуулийг сахидаг, харин 1998 оны хуульд хуулийг дээдлэн сахидаг иргэнтэй болох нь зорилго байсан бол 2002 оны хуульд хүмүүнлэг ёсыг сахидаг иргэнтэй болох гэж өөрчлөгдсөн байх жишээтэй. Үндсэн хуульдаа ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх талаар зарлан тунхагласан хэр нь боловсролын эрх зүйн суурь эх сурвалждаа хууль ёсыг дагаж мөрддөг иргэн төлөвшүүлэх гэсэн заалтаа хассан эдгээр өөрчлөлтүүд ямар учир шалтгаантай нь тодорхойгүй үлджээ.

Бас 1991, 1995 оны хуульд шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэх нь боловсролын чухал зорилго болж байсан бол 1998 оноос амьдрах чадварт сургах, 2002 оноос ажиллаж, амьдрах чадвартай болгох гэх мэт хувьсан өөрчлөгдсөн байх жишээтэй. Боловсролын хуулийн зохицуулалтын тасралтгүй өөрчлөлт, хувирамтгай байдал нь Монголын улсын боловсролын зорилго чиглэл тогтвортой бус байгааг илтгэж байна.

Үүний учир шалтгааныг эрэлхийлэх үүднээс зарим нэг улсын туршлагыг анхаарч үзэхийг хичээв. Тухайлбал,

Нэгэн үед манайхтай төстэй гэмээр нөхцөлд орсон Япон улсын туршлагаас судалж үзвэл, Мейжийн үед \1868 оноос эхлэлтэй\ Япон улс өөрийн хатуу дэгтэй гэдгээрээ онцлогтой шинэ боловсролын удирдлагын тогтолцоог Францаас, цөөн элит үндэсний их сургууль тойрч байгуулагдсан боловсролын тогтолцооны санааг Германаас, хүчирхэг ёс суртахууны зарчмуудад үндэслэн байгуулсан сургуулийн загвар (Этон, Харров гэх мэт нийтийн сургууль)-ыг Англиас хуулбарласан байдаг. Мэдээж Америкийн нөлөөлөл өндөр байсан нь ойлгомжтой.

Гэтэл 1880-аад оноос Мейжийн засгийн газар боловсролын салбарын шинэчлэлийг бусдаас хуулбарлах үйл явцыг гол болгож байгаа нь нийгэм, олон нийтийн хүчтэй эсэргүүцэл, шүүмжлэлтэй тулгарсан. Ялангуяа, жинхэнэ Япон хүн байхын утга учир, мөн чанар алдагдаж байгааг олон талаас нь шүүмжилсэн байдаг (Монголоо алдах гэх хэлцтэй төстэй).

Ингээд 1890 онд Япон улсын эзэн хаан “кёоикүчёкүго” гэх боловсролын тухай зарлиг гаргаж, боловсролд удирдлага болгох суурь үзэл баримтлалыг тунхагласан байна. Үүнд, үнэнч зүтгэл, ахмадын хүндлэл, нийгмийн бүлэг, хамт олны \гэр бүл, найз нөхөд, хөршүүд, ажлын хамт олон гэх мэт\ өмнө хариуцлагатай, нэр хүндтэй

байх, даруу төлөв байхын ач холбогдол, өөрийгөө чадах чинээнд хүртэл зайлшгүй боловсруулах явдал, үндсэн хууль болон бусад хуулийг дагаж мөрдөх үүрэг зэрэг Күнзийн ёс суртахууны чанаруудыг чухалчилсан байна. Зарлиг гарсан цаг үеэс Японы боловсролын бодлого нь уламжлалт үнэт зүйлст бэт бэх суурилах болжээ (OECD. 2011). Үүнийг Японы боловсролын хуулийн суурь үзэл баримтлал бөгөөд одоо хэр хадгалагдсаар байна. Эл үзэл баримтлалыг тунхагласны шалтгааныг судлаачид тухайн үндэстнийг амьдралын хүнд сорилын өмнө аваачих газар зүйн орчин, амьдралын нөхцөл нь хувь хүнээс илүүтэйгээр хамтын сайн сайхан, хамтын эв зохицлыг эрхэмлэхэд хүргэсэнтэй холбоотой гэж дүгнэдэг.

Харин Японы 2014-2016 онд явуулж, 2017 онд баталсан бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн шинэчлэл нь өмнөх уламжлалаа хадгалахыг зэрэгцээ сурагчдад нийгэмд амьдрахад зайлшгүй хэрэгтэй мэдлэг, ёс суртахуун, бие бялдрын хөгжил гэсэн 3 хүчин зүйлд анхаарч, прагматик чиг баримжаатай зарим өөрчлөлтийг орууллаа.

Боловсролын салбараа амжилттай хөгжүүлсэн Герман улсын хувьд “хэдийгээр боловсролын шинэчлэлийн хурдтай үйл явц өрнөсөөр ирсэн ч Германы боловсролын эцэг гэгдэх Вильгельм вон Гумбольдтын “боловсролын хамгийн гол зорилго бол амьдралаа залгуулж орлого олоход хэрэгтэй мэдлэг ухаан бус, харин “ёс суртахуун” ба “гоо сайхан” гэсэн үзэл санааг боловсролын үндэсний үнэт зүйл болгон өнөө хүртэл баримжаалсаар иржээ.

Судлаачид Хятадын боловсролын уламжлалыг Күнзын гүн ухаантай холбон тайлбарладаг. (Бернхард Нагел, 2017, до²⁴) 1995 оны Хятадын боловсролын тухай хуульд, үндэстний хөгжин цэцэглэх чухал нөхцөл нь боловсролын тогтолцоог боловсронгуй болгон өргөжүүлэх явдал юм” гэж тодорхойлсон. <http://www.china.org.cn/english/education/>

Мөн Дэн Сяопин, Мао Цедуны үед маш ихээр шүүмжлэлд өртөж байсан Күнзийн номлолыг баримтлан ухаалаг бодлого явуулснаар Хятадын боловсролын олон жилийн өв уламжлалыг сэргээж чаджээ. Олон улсын боловсролын үнэлгээд чамлахааргүй амжилттай яваа Сингапур болоод Хонг Конгийн боловсролын чанарыг Хятад үндэсний өвөрмөц соёл, үнэт зүйлийг хадгалсантай холбоотой хэмээн судлаачид тайлбарлаж байна. (Клепиков, В.З, (2002). Хятадын боловсролын шинэчлэлийн тухай. Боловсрол судлал, дугаар 3, х-54) \шударга үнэн зан чанар, амжилтыг тууштай хөдөлмөрийн

үр дүнд олно, даруу төлөв зан, хамтын сайн сайхны төлөө зүтгэх\

Эдгээр улсын боловсролын үнэт зүйлийн баримжаа нь:

1. Боловсролд хийж буй өөрчлөлтийн бодлогыг тодорхой хугацааны дараа эргэн нягталж алдаа, оноогоо шүүн шинжилсэн байна
2. Ийнхүү эргэн нягталсны үр дүнд эдгээр улсын боловсролын зорилго, чиглэлийг өөрийн үндэсний уламжлал, үнэт зүйлд хандуулж, тэдгээрийг хадгалах өвлүүлэх бодлого баримталсан
3. Ийнхүү үндэсний уламжлалыг тэргүүн байранд тавьсан шалтгаан бол аль ч улсын боловсролын үйлчилгээ нь тухайн улсын гэх онцлогтой иргэн төлөвшүүлэхэд чиглэнэ. Тухайлбал, Японы боловсрол япон хүнийг, Германы боловсрол Герман хүнийг.

Иймд соёл иргэншлийн холимог хэлбэр бүхий Монгол орны өвөрмөц онцлогийг харгалзан үзэж, үндэсний өвөрмөц соёл, үнэт зүйлд тулгуулсан боловсролын хуулийн үзэл баримтлалыг тодорхойлж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бидэнд тулгарч байна. Аливаа үндэстэн бүр өөр өөрийн амьдралын хэв маяг, соёл, уламжлал, оршин амьдарч буй байгал цаг уурын нөхцөл байдал, газар нутаг зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өвөрмөц онцлогтой. Өөрөөр хэлбэл нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон манай улсын хувьд суурин соёл иргэншлийн өнө удаан жилийн уламжлал бүхий улсуудын боловсролын загварыг туршин хэрэгжүүлэх нь үр дүнтэй байж чадсангүй гэж үзэж байна.

Тэгвэл манай улсын боловсролд ямар үнэт зүйл уламжлагдан ирснийг дараах баримтаар үзүүлж болох юм. Жишээ нь, 1924 онд Ардыг гэгээрүүлэх яамны анхны сайдаар томилогдон ажиллаж байсан Эрдэнэбатхааны бичсэн өгүүлэлд “Сурагч хүүхэд тус тусын бие сэтгэл ба ухаан бодол нь адилгүй тул тэдгээрийн дотоодын чанарыг засан сайжруулахдаа ийнхүү адилгүй явдлыг мөн хянаж багшаас сурах төлөвтэй, сурах төлөвгүй мунхаг буюу хичээлтэй, хичээлгүй, нарийн нягт ба бүдүүлэг болохтой болохгүйг ч ялган сурган хүмүүжүүлж буй хүүхдээ чадал савд нь тааруулан сургаж мэргэн бодол, олонд тустай сайн үйлсийн мөрд оруулахыг хичээнэ” (Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүллэгийн түүвэр /XX зуун/, 2002) гэсэн манай цөм хөтөлбөрийн үндсэн санааг гаргасан байх юм. Энэ мэтийн жишээ баримт олныг дурдаж болох бөгөөд энэ бүхэн нь

өөрийн улсын боловсролын зорилго чиглэлийг тодорхойлоход ашиглаж болохуйц эх сурвалж мөн. Бид өөрийн үүх, түүхийг судлахгүйгээр уламжлал, соёлд хандахгүйгээр боловсролын олон улсын стандартад хүргэнэ гэсэн нэрийн доор 2012 онд Кембрижийн их сургуулийн дэргэдэх Боловсролын төвийг уламжлалынхаа оронд сонгож, хөтөлбөрийг нь хэрэгжүүлэхийн тулд хуулиа засварласаар ирлээ. Ийм үзэгдэл нь хуулийг дур зоргоороо өөрчлөхөд хүргэж байна. Ганцхан жишээ дурдахад, 2002 оны Боловсролын тухай хуульд жишээ болгон авч үзвэл 2002 онд батлагдсан цагаас хойш 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Боловсролын салбарынхан хөтөлбөр, сурах бичиг жил болгон өөрчлөгдөж байгаа талаар анзаарч шүүмжилдэг ч суурь хууль нь жилд хэд хэдэн удаа өөрчлөлт орж, энэ бүх тогтворгүй байдлын үндсийг тавьж байгааг тэр бүр ярихгүй байна. Энэ бол зорилго нь тогтворгүй боловсрол эрх зүйн зохицуулалтаа дархлаагүй болгож байгаагийн илэрхийлэл мөн.

Цаашлаад дэлхийн улс орнуудын жишиг болгоод байгаа хүн хэрхэн төлөвшдөг, мэдлэг яаж бүтдэг, мэдлэгийн үнэ цэнэ юугаар тодорхойлогддог болох талаар авч үздэг конструктивизм, прагматизм гэх мэт үзэл хандлагуудад анхаарал хандуулах нь зүйн хэрэг. Манай шинэчлэгдсээр байгаа хөтөлбөрийн агуулгад эдгээр үзэл, хандлагыг баримжаалсан эсэхийг эрх зүйн судлагдахууны хүрээнд авч үзье. Манай Улсын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эрх зүйн боловсрололгожирсэнтүүхийг сөхөн үзвэл манай улс 1938 оноос эхэлнэ. Энэ үеэс 7 дугаар ангид “БНМАУ-ын үндсэн хууль”, 1975 оноос эхэлж 8 дугаар ангид “БНМАУ-ын төр эрхийн үндэс”, 1987 оноос 9 дүгээр ангид “Эрх зүй, ёс суртахуун” хичээлүүдийг зааж эхэлсэн байдаг. 1994 оноос 6-8 дугаар ангид “Эрх зүй”, 1998 онд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх зүйн хичээлийг шинэчлэн хөгжүүлэх талаар шийдвэр гаргаж, 1-10 дугаар ангид “Эрх зүй” хичээл, “Иргэншил”, харин 2004 оноос өнөөг хүртэл Нийгмийн ухаан хичээлийн нэг айн хүрээнд нийтийн эрх зүйн боловсрол олгодог. Одоогийн байдлаар бид боловсролын орчин үеийн үзэл хандлагыг харгалзан үзэхийг зорьж байгаа боловч эрх зүйн хөтөлбөрийн агуулга социалист нийгмийн үеэс өөрчлөгдсөн дээрдсэн гэж дүгнэх бололцоогүй байна. Тухайлбал, энгийн иргэдийн хувьд эрх зүйн харилцаанд оролцох, наад захын хүрээнд эрх ашгаа хамгаалах чадварт суралцахад чиглэсэн мэдлэг, чадвар олгох асуудалд тэр бүр анхаараагүй гэж судлаачийн хувьд дүгнэж байна. Энгийн жишээ татахад 1938 он бид Үндсэн хууль,

төрийн эрх зүйг нийтийн эрх зүйн боловсролд гол болгон зааж байсан бол өнөөдөр ч тэр байдал хэвээр үргэлжилсээр байна гэж хэлэхэд буруудахгүй. Иргэн нь иргэнийхээ хууль, төр нь төрийнхөө хууль, сургууль нь сургуулийнхаа хуулийг судалж, хэрэгжүүлдэг байж боловсролын прагматизмын үзэл хандлагыг баримжаалсан гэх үнэлгээ авна. Бид боловсролын онол, хандлагыг ч үл харгалзан “шилдэг шалгарсан хөтөлбөр” боловсруулсаар ирсэн гэж дүгнэж хэлмээр байна.

Эцэст нь дүгнэхэд нэн тэргүүний шаардлага бол төр солигдоход сургалтын хөтөлбөрөө өөрчилдөг, энэхүү өөрчлөлт нь гүйцэтгэх засаглалын байгууллагын тодорхойгүй ашиг сонирхлын үндсэнд хийгдэх бөгөөд эрх ашгаа хэрэгжүүлэхийн төлөө хууль засдаг тогтолцоог халах цаг болжээ. Учир нь зорилго тодорхой, хөдөлшгүй үзэл баримтлалтай хуульд халдах боломж хязгаарлагдмал байдаг. Иймээс Монгол улсын боловсролын, тэр дундаа, бүрэн дунд боловсролын зорилгыг өөрийн соёл, уламжлал, үнэт зүйлс, орчин цагийн онолын хандлагад тулгуурлан тодорхойлох шаардлагатай. Үүний дараагаар тэрхүү зорилгодоо чиглэсэн тууштай, тогтвортой үйл ажиллагаа явуулах нь чухал байна. Хөтөлбөрийн шинэчлэл хийдээ агуулгыг үл харгалзан арга зүйн шинэчлэл, шинэ хөтөлбөр хийхэд хэт анхаарч байна.

Боловсролын шинэчлэлийг бол суурь үзэл баримтлал, зорилго чиглэл тодорхойлох ажлаас эхлэх нь зүйлтэй болов уу.

Ном зүй

- Боаз, Д.(2005). Либертарианизм. Улаанбаатар: Мөнхийн үсэг хэвлэлийн газар,
Ган-Өлзий, Ч. (2013). Эдүгээгийн философи. Улаанбаатар: Битпресс ХХК,
Ханс Кельзен. (2017). Хэм хэмжээний тухай ерөнхий онол. Улаанбаатар, ХЗҮХ хэвлэх үйлдвэр.
Шагдар, Ш. (2000). Боловсролын түүхэн товчоон бүтээл. Улаанбаатар: Соёмбо притинг,
Бэгз, Н. (2017). Боловсролын хөгжлийн бодлого. Боловсрол судлал, 04(132)
Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүллэгийн түүвэр /XX зуун/, (2002). Улаанбаатар: Мөнхийн үсэг хэвлэлийн газар,
БСШУЯ. (2014). Боловсролын салбарын эрх зүйн түүхийн эх сурвалж. Улаанбаатар: Монгол. Ган принт
Жон Дьюи. Боловсрол ба ардчилал. (2013). (Т.Нэмэхжаргал. Орч), Улаанбаатар: Битпресс ХХК

(Др.Бернхард Нагел. Боловсрол дахь бодлогын сонголт. Илтгэлээс)
 OECD. (2011). Lessons from PISA for the United States, Strong Performers and Successful Reformers in Education. OECD publishing
 (<http://www.china.org.cn/english/education/184669.htm>)
<https://www.perfar.eu/policy/education/finland>
 (Монгол улсын үндсэн хууль 1992 он)

(Сургууль амьдралын холбоог бэхжүүлж, ардын боловсролын системийг хөгжүүлэх тухай хууль 1963 он)
 (Бүгд найрамдах Монгол ард улсын ардын боловсролын тухай хууль 1982 он)
 (БНМАУ-ын боловсролын тухай хууль 1991 он)
 (Монгол улсын боловсролын тухай хууль 1995он)
 (Боловсролын тухай хууль 2002 он)

The purpose of high education of Mongolia, tradition and reform: analysis of legal norms

*Chuluuntsetseg.E,
 Department of Social Science,
 School of Humanities and Social Science of
 Mongolian National University of Education*

Abstract

Minister of MECSS stated that they will look back on and make changes to the ongoing “Comprehensive project to develop every children”. There wasn’t any certain “must change” reason in the motive why they decided to make changes to this project. We have been restructuring and making changes to education sector, implementing projects such as student centered education program, education program based on the study, performance and results, cambridge education program, “Talent”, “Book”, “Mongolian children with good behaviors” programs in the frame of comprehensive project to develop every children and various follow-up projects in last few years. It is a good thing that there was a non-stop research and implementation of distinguished positive experiences but “...restructure and changes are supposed to bring development to this sector but it wasn’t able to reach their supposed goal everytime” (Begz, 2017, p.10). You can say that many changes in the name of restructure in last few years shows that our education sector is unstable. On the other hand, it’s related to the way legal regulation is unstable and underdeveloped. Because democracy is governance of law and democratic country is empire of law. Our country which is democratic and belong to mainland must have the government execute and institute ideology and principles of everyone’s education. But it’s not a rare thing to see that some actions are not administrated by law but certain subject who make changes to the law according to their interests. The executive branch on purpose of reaching their goal has been making changes to law to their liking which they think it’s beneficial up to this date. This is representation of no ideology and weak administration of educational law. Thus, in this presentation we seeked to emphasize certain things. First, how we have been determining goal and ideology of education in legal norms which has been moderating since our country started education process to this day. Second, to research how much of our education restructuring process is preserving traditions and national values. Third, some factors that would ensure efficiency and stability of everyone’s education.

Keywords

Laws, changes, values, policies, history